

2012.04.27- ний өдрийн “Махимпэкс” ХК-ийн
Хувьцаа Эзэмшигчдийн хурлын №03 тоот
Тогтоолоор батлав.

“МАХИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙ ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 “Махимпэкс” ХК нь (цаашид компани гэж нэрлэнэ). Монгол улсын “Компанийн тухай” хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд болно.
- 1.2 Компанийн төв нь Улаанбаатар хотын Сонгино Хайрхан дүүргийн 4-р хороо, Хүнсчдийн гудамж, өөрийн байранд байрлана.
- 1.3 Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд төр засгийн бодлогыг хүндэтгэж, бизнесийн үйл ажиллагааг бие даан явуулна.
- 1.4 Компани нь үйл ажиллагаатай холбогдох үүргийг эд хөрөнгөөрөө хариуцна.
- 1.5 Компани нь банк, санхүү, статистикийн байгууллагад тэдгээрээс тогтоосон хууль журмын дагуу мэдээ тайлан гаргаж өгнө.
- 1.6 Компани нь гадаад, дотоод худалдаа, хүнсний үйлдвэрлэл эрхлэнэ.
- 1.7 Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн эдийн засгийн гадаад харилцаанд бие даан оролцоно.
- 1.8 Компани нь дотоодын болон гадаадын орнуудын хуулийн этгээд байгууллагуудтай гэрээ хэлцэл хийж хамтран ажиллана.
- 1.9 Компани нь өөрийн салбар, охин компани, төлөөлөгчийн газар байгуулж, ажиллуулж болно.
- 1.10 Компани нь өөрийн бүрэлдэхүүн үйлдвэр, нэгжүүдийн үйл ажиллагааг компанийн дотоод журмын дагуу зохицуулна.
- 1.11 Компани нь хүнс, барааны дэлгүүр, гуанз зэрэг бусад үйлчилгээний салбар нэгжүүдийг дангаар буюу хоршин байгуулан ажиллана.
- 1.12 Компани нь төрөл бүрийн хурал, семинар, симпозиум, үзэсгэлэн зэргийг зохион байгуулах ба тэдгээрт оролцоно.
- 1.13 Энэхүү дүрэмд заагаагүй бусад асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулах бөгөөд дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах хүртэл шуурхай шийдвэрлэх тулгамдсан асуудлыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

ХОЁР. КОМПАНИЙН ХӨРӨНГӨ ХУВЬЦАА

- 2.1 Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн нийт дүнгээс компанийн өр төлбөрийг хасаж үлдсэн хэсэг нь компанийн өөрийн хөрөнгө буюу хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө болно.
- 2.2 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг нэг бүр нь ...100... төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт ...3800721... ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
- 2.3 Компанаис гаргасан хувьцаа нь тэдгээрийг компани худалдан авах буюу эргүүлэн авах эсвэл бусад төрлийн үнэт цаас эд хөрөнгөнд хөрвүүлэх хүртэл эргэлтэнд байна.
- 2.4 Компани нь өөрийн хувьцааг худалдан авах буюу эргүүлж авбал эдгээр хувьцааг зарласан боловч гаргаагүй хувьцаа гэж тооцох бөгөөд харин компани эдгээр хувьцааг дахин гаргаж болно.
- 2.5 Компанийн худалдаж авах хувьцааны хэмжээг Төлөөлөн Удирдах Зөвлөл тогтооно. Компани өөрийн үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргах үед тэдгээрийг худалдан авч үл болно.
- 2.6 Хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж болох энгийн хувьцааны тоог хязгаарлахгүй бөгөөд энгийн хувьцааг компанийн давуу эрхийн хувьцаа бусад үнэт цаасанд хөрвүүлэхгүй болно.
- 2.7 Компанийн гаргасан энгийн хувьцаанд хөрвөх үнэ нь тухайн энгийн хувьцааны зах зээлийн үнээс доогуур байж болохгүй.
- 2.8 Компани нь өөрийн эд хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа хүү төлж эргүүлэн авах нөхцөлтэйгээр өрийн бичиг гаргаж болох бөгөөд шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргана.
- 2.9 Компанийн зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, бусад төрлийн үнэт цаас гаргах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Шийдвэрт үнэт цаасны төрөл тоо хугацаа нөхцлийг заана.
- 2.10 Нийтэд худалдахаар гаргаж байгаа үнэт цаас болон хувьцааг үнэт цаасны тухай хуульд заасны дагуу үнэт цаасны хороонд бүртгүүлнэ.
- 2.11 Компанийн гаргасан үнэт цаасны төлбөрийг худалдан авч байгаа этгээд нь мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хийж болох бөгөөд мөнгөн бус хэлбэрээр хийх үнэлгээг ТУЗ шийдвэрлэнэ.

- 2.12Компани нь үнэт цаас эзэмшигчдийнхээ бүртгэлийг бүртгэх бөгөөд үнэт цаасны биет бус хэлбэрээр гаргаж байгаа тохиолдолд үнэт цаас эзэмшигчдэд тэдний эрхийг нотолсон баримт сертификат олгоно.
- 2.13Компанийн ногдол ашиг хувиарлах шийдвэрийг ТУЗ гаргана.
- 2.14Компанийн ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- 2.15Ногдол ашиг төлсөний дараа компани нь төлбөрийн чадвартай байх нөхцөлд энгийн хувьцаанд ногдох ашгийг хувиарлах бөгөөд өөрийн эргүүлэн авсан хувьцаанд ногдол ашиг хувиарлахгүй.
- 2.16Компани нь ногдол ашиг хувиарлаагүй тохиолдолд ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд шалтгааныг нь тайлагнана
- 2.17Компани нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд өөрийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг бусдад зах зээлийн үнээс доогуур үнээр худалдаж үл болно.
- 2.18Компанийн эд хөрөнгө эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг ТУЗ тогтооно. Тогтоохдоо хараат бус үнэлгээний байгууллага, аудиторын дүгнэлтийг ашиглаж болно.
- 2.19Нийтэд худалдаж байгаа хувьцаа болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийг тогтоохдоо хөрөнгийн биржийн албан ёсны мэдээнд тусгагдсан арилжааны сүүлийн 6 сарын ханшийг харгалзан тогтооно.

ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 3.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал болно.
- 3.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит ба ээлжит бус хурал хийнэ.
- 3.3 Ээлжит хурлыг компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна.
- 3.4 Дараах тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.
- а/ ТУЗ-ийн шийдвэр гарсан
 - б/ Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн санал, шаардлагаар
 - в/ ТУЗ-ийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүний санал шаардлагаар

- г/ Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсанаар
 - д/ ТУЗ-ийн нийт гишүүдийн 50-с дээш хувь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон
 - е/ Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн
 - ё/ Компанийн өр нь 2 жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж хасах утгатай болсон
 - ж/ Компанийн дүрэмд заасан бусад тохиолдолд
- 3.5 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг тухайн хурлаас сонгогдсон дарга буюу ТУЗ-ийн дарга удирдан явуулна.
- 3.6 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 3.7 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргана.

Үүнд :

- а/ Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, түүний шийдвэр найрууллагыг батлах
 - б/ Нийлэх, нэгдэх, хуваах буюу компанийг өөрчлөн байгуулах,
 - в/ Компанийн өрийг хувьцаагаар солих
 - г/ Компанийг татан буулгах тухай
 - д/ ТУЗөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох,
 - е/ Компанийн жилийн үйл ажиллагаа болон, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.
 - ё/ ТУЗ ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоон баталж өгөх
 - ж/ ТУЗ ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх бусад асуудал
- 3.8 Хурал хуралдуулах шийдвэрт дараахь зүйлийг тусгана.
- а/ Хурал хуралдуулах газар, өдөр, цаг
 - б/ Хурлын хэлэлцэх асуудал

- в/ Хувьцаат компанийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр
- г/ Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр журам
- д/хурлын материал
- е/санал авах тохиолдолд саналын хуудас хүргүүлэх журам

3.9 Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх нь “Компанийн тухай” хуулийн 62-р зүйлд зааснаар хэрэгжинэ.

ДӨРӨВ.ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 4.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна.
- 4.2 ТУЗ нь 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.
- 4.3 ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас 3 жилийн хугацаатай сонгоно
- 4.4 ТУЗ-ийн хурлаас гишүүдийн олонхийн саналаар даргаа сонгон батална.
- 4.5 ТУЗ-ийн гишүүн болон нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байна.
- 4.6 ТУЗ нь аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

ТАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

- 5.1 ТУЗ нь “Компанийн тухай” хууль, энэхүү дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулахаас бусад дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Үүнд:

- 1. Компаний үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах
 3. Компанийн хувьцаа гаргах
 4. Компанийн үнэт цаас гаргах
 5. Эд хөрөнгө, бүтээгдэхүүн, эд хөрөнгийн зах зээлийн үнийг тогтоох
 6. Өөрийн гаргасан хувьцаа, үнэт цаас эргүүлэн авах
 7. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох
 8. Гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулах, олгох шагнал, урамшуулал, цалин, хариуцлагын хэмжээг тогтоох
 9. Компанийн аудиторыг сонгож, гэрээний нөхцлийг тогтоох
 10. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах
 11. Ногдол ашгийн хэмжээг тогтоох
 12. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг батлах
 13. Компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах
 14. Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх
 15. Их хэмжээний хэлцэл байгуулах, зөвшөөрөл олгох болон “Компанийн тухай” хуульд заагдсан бусад асуудлыг шийдвэрлэх
- 5.2 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, хурал хуралдуулах, хурал даргалах, тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.
- 5.3 ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон гишүүн энэ ажлыг хариуцана.
- 5.4 ТУЗ-ийн хурлыг сар бүр хуралдуулж асуудлыг шийдвэрлүүлнэ. Хурлын шийдвэр нь тогтоол байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж компанийн тэмдэг дарснаар баталгаажна.
- 5.5 ТУЗ-ийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоож, хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэн батлуулна.
- 5.6 ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно. Нарийн бичгийн даргын урамшууллыг ТУЗ-өөс тогтооно.

- 5.7 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хурлын тэмдэглэл болон холбогдох бүх бичиг баримт, бичиг хэргийг хариуцахаас гадна ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулна.
- 5.8 Компанийн ерөнхий захирлын өмч хөрөнгийн захиран зарцуулах эрхийг гэрээгээр зохицуулна.
- 5.9 ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хуралд жилд нэгээс доошгүй удаа тайлан тавина.
- 5.10 Компанийн бүтэц, цалингийн фондын хэмжээг тогтооно.
- 5.11 ТУЗ-ийн хараат бус гишүүнд “Компанийн тухай” хуулийн 79-р зүйлийн 1.1-1.4-д заасан шалгуурыг хангасан хүний нэрийг дэвшүүлнэ. Хараат бус гишүүн нь ТУЗ-ийн бусад гишүүдийн адил эрх үүрэгтэй байхаас гадна “Компанийн тухай” хуулийн 79-р зүйлийн 3.1-4.2-д заасан нэмэлт үүргийг хүлээнэ.

ЗУРГАА. АУДИТЫН ХОРОО

- 6.1 Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд дараахь чиглэлээр дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна. Үүнд:
1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих
 2. Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах
 3. Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах
 4. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах
 5. ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал

ДОЛОО. НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

- 7.1 Нэр дэвшүүлэх хороо нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

а\ Компанийн ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох

б\ ТУЗ ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд “Компанийн тухай” хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх

в\ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх

г\ ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх

д\ Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах

е\ ТУЗ-ийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт өгөх

ё\ “Компанийн тухай” хуулийн 59.5-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд тухайн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхээс татгалзах

НАЙМ. ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

8.1 Цалин Урамшууллын Хороо нь дараахь чиглэлээр дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна.

а\ Компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих

б\ ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах

в) Компанид мөрдөгдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх


ЕС. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 9.1 Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 9.2 Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр ТУЗ-тэй зөвшилцөн тогтоосон эрх хэмжээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 9.3 Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-тэй зөвлөлдсөний үндсэн дээр өөрийн удирдах зөвлөлийн багийг бүрдүүлж, ТУЗ-өөр батлуулан мөрдөж ажиллана.
- 9.4 Гүйцэтгэх удирдлага нь хурлаас гарсан шийдвэрийн тэмдэглэл хөтөлж, биелэлтэнд хяналт тавина.
- 9.6 Гүйцэтгэх удирдлага нь өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, санхүүгийн үйл ажиллагааг биечлэн удирдана.
- 9.7 Ажилд авах, халах, өөрчлөх, ажлын байр шинээр бий болгох, татан буулгах зэрэг ажлуудыг холбогдох байгууллага, ҮЭНХ-той зөвшилцсөний үндсэн дээр хөдөлмөрийн болон хамтын гэрээ, бусад хууль тогтоомжийн хүрээнд явуулна.

АРАВ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 10.1 Компанийн эрх бүхий албан тушаалтанд компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий санхүүч, борлуулалтын албаны дарга, дотоод ажлын албаны дарга, ерөнхий менежер, эдийн засагч, албад, үйлдвэрийн дарга нар хамаарна.

- 10.2 Эрх бүхий албан тушаалтан нь Компанийн дүрэм, ТУЗ-ийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.
- 10.3 ТУЗ-ийн зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд компанийн нууц мэдээг 3 дахь этгээдэд дамжуулах, хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.
- 10.4 Эрх бүхий албан тушаалтан нь өөрийн хууль бус ажиллагаанаас болж компанид учирсан хохирлыг өөрөө хариуцана.
- 10.5 Эрх бүхий албан тушаалтны учруулсан хохирлыг ТУЗ-өөр болон дотоод журмын дагуу шийдвэрлэж болохгүй нөхцөлд хуулийн байгууллагаар шийдвэрлэнэ.
- 10.6 Хэд хэдэн этгээд хамтарч хариуцлага хүлээхээр бол хамтын хариуцлага хүлээнэ.
- 10.7 Эрх бүхий албан тушаалтан нь санаатайгаар хууль бус үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хувь нийлүүлсэн зээлдүүлэгчдэд учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна. Үүнд:
- а\ Хувийн ашиг сонирхлын үүднээс компанийн нэрийг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулсан
 - б\ “Компанийн тухай” хуулийн 99-р зүйлд заасан шаардлага, зарчим, нэгдмэл сонирхол бүхий этгээд болохоо мэдэгдээгүй.
 - г\ Компанийн бичиг баримт хадгалах талаар “Компанийн тухай” хуулийн 97-р заалт зөрчсөн
 - д\ Ногдол ашиг хуваарилах, хувьцаа худалдан авах, эрхийн бичгийг эргүүлэн авах нөхцлийг мөрдөөгүй
 - е\ ТУЗ-тэй байгуулсан гэрээ, Компанийн дүрмээр тогтоосон эд хөрөнгө захиран зарцуулах эрх хэмжээгээ хэтрүүлсэн
- 10.8 Эрх бүхий албан тушаалтан нь “Компанийн тухай” хуулийг зөрчвөл тус хуулийн 100-р зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.



АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ

11.1 Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана.

а\ Баланс

б\ Орлого, үр дүнгийн тайлан

в\ Мөнгөн гүйлгээний тайлан

г\ Хуримтлагдсан ашгийн тайлан

д\ Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт

е\ Нэмэлт тайлбар

ё\ Бусад

11.2 Компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигч нарт зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан, илтгэл бичиж хүргүүлнэ.

11.3 ТУЗ нь санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг заавал томилон ажиллуулна.

11.4 Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэй оролцоно.

11.5 “Компанийн тухай” хуулийн 94.13-д заасан этгээдийг компанийн аудиторроор сонгон ажиллуулахыг хориглоно.

11.6 Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жилийн ажил эхлэхээс өмнө зохих байгууллага, хамт олноор хэлэлцэн байгуулж мөрдөн ажиллана.

11.7 Компанийн нягтлан бодох бүртгэлийг зохих хууль дүрмийн дагуу бүрэн хөтөлж эрх бүхий байгууллагад танилцуулна.

11.8 Сар, улирал, жилийн тайлан баланстай байх ба заасан хугацаанд гаргаж холбогдох байгууллагад хүргүүлнэ. Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт

мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрхи газруудад хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

- 11.9 Компаний санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна. Жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ний өдрийн дотор гаргаж холбогдох газруудад хүргүүлнэ.
- 11.10 Компанийн нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв эсэхийг Гүйцэтгэх удирдлага хариуцана.
- 11.11 Компанийн санхүү аж ахуйн үйл ажиллагаа, тайлан тэнцэлд жил бүр шалгалт хийлгэж баталгаажуулна.

АРВАН ХОЁР. КОМПАНИЙН БИЧИГ, БАРИМТ ТҮҮНИЙГ ХАДГАЛАХ

12.1 Компани нь дараахь бичиг баримтыг заавал хадгалах үүрэгтэй. Үүнд:

- а\ Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- б\ Компанийн дүрэм, дүрэмд орсон өөрчлөлт, компанийг байгуулсан тухай шийдвэр, хурлын материал
- в\ Хувьцаа эзэмшигчдийн, ТУЗ түүний дэргэдэх хороодын болон Гүйцэтгэх байгууллагаас баталсан компанийн дотоод бичиг баримт
- г\ Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт биичгүүд
- д\ Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, хамтын удирдлагын гүйцэтгэх байгууллагын хурлын тэмдэглэл, компанийн гүйцэтгэх удирдлагын тушаал шийдвэр
- е\ ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлын бүх материал, санал дүгнэлт, аудиторын дүгнэлт
- ё\ Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
- ж\ Хувьцаа болон үнэт цаас гаргах журам
- з\ Нягтлан бодох болон анхан шатны бүртгэлийн бичиг баримт
- и\ Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт, хувьцааны төрөл, тоо /тархалтын судалгаа\
- й\ Бусад дотоод бичиг баримтууд болно.

- 12.2 Холбогдох бичиг баримтыг 5 жилийн хугацаагаар хадгалах бөгөөд хугацаа дуусмагц архивт шилжүүлнэ.
- 12.3 Энэхүү дүрэмд тусгагдаагүй хуулийн хүрээнд хийгдэх ажлууд Монгол Улсын “Компанийн тухай” хууль, “Хөдөлмөрийн тухай” хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулагдана.
- 12.4 Компанийн дүрэм нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж бүтргэх байгууллагад бүртгүүлснээр энэхүү дүрэм хүчин төгөлдөр болно.

